

ЭРЭЛЧ НОХОЙН СУРГАЛТЫН ТӨВИЙН ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ АНХБАЯРЫН ЭНХ-АМГАЛАНГИЙН
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
Зорилт 4. “ Хууль ёсны худалдааг хөнгөвчлөх”							
1.	Албаны эрэлч нохойн амьдрах, сургах орчин нөхцөлийг сайжруулсан байдал.	1. Албаны эрэлч нохдыг хоолоор 100 хувь хангана. 2. Албаны эрэлч нохдыг эм тариагаар 100 хувь хангана.	1. 2024 онд гаалийн албаны эрэлч нохдыг эм тариа, зориулалтын хоолоор 100 хувь хангасан. 2. 2024 онд 53 эрэлч нохойтой байсан.	Эхний хагас жилд: - Нохойн хоолны судалгаа хийж, холбогдох хууль журмын дагуу худалдан авах ажиллагаа зохион байгуулж, эрэлч нохдыг зориулалтын хоолоор хангах ажлыг эхлүүлсэн байна. - 4 эрэлч нохойгоор газар хороодод нөхөн хангалт хийсэн байна. - Албаны эрэлч ноход хоол, эм тариагаар 100 хувь хангагдсан байна. - Эрэлч нохойн үүрийг цэвэрхэн байлгаж ариутгах халдваргүйжүүлэлт	1. ГЕГ-ын даргын 2025 оны 01 сарын 4-ны өдрийн № А/06 тоот “Үнэлгээний хороо байгуулах тухай” тушаалаар Гаалийн ерөнхий газрын дэргэдэх Эрэлч нохойн сургалтын төвийн албаны эрэлч ноходод зориулалтын хоол нийлүүлэх харьцуулсан тендерийн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах зорилготойгоор зохион байгуулагдсан. 2025.02.04-ны өдөр ГЕГ/20250102005/01/01 урилгын дугаартай тендерийн сонгон шалгаруулалтад “Аз болор мөнх трейд” ХХК ирүүлсэн материал шаардлага хангаж сонгогдсон. Тус компанитай худалдах худалдан авах гэрээ байгуулах ажил хийгдэж Эрэлч нохойн сургалтын төв нь 2025 оны 04 сарын 07-ны өдөр 9 тн 860 кг нохойн хоолыг хүлээн авсаны дараа харьяа гаалийн газар хороодод ажиллаж байгаа эрэлч нохдыг хоолоор хангасан. 2. 2025 оны эхний хагас жилд гаалийн ерөнхий газрын харьяа 4 газар хороодод шинээр 5 эрэлч нохойгоор нөхөн хангалт хийсэн. Үүнд: 2.1. Улаанбаатар хот дахь гаалийн газарт 2 эрэлч нохой. 2.2. Баян-Өлгий аймаг дахь гаалийн газарт 1 эрэлч нохой.	01.01-06.30	100

				тогтмол хийсэн байна. Сүүлийн хагас жилд: - Албаны эрэлч ноход хоол, эм тариагаар 100 хувь хангагдсан байна. - Эрэлч нохойн тоог 4-өөр нэмэгдүүлсэн байна. - Эрэлч нохойн үүрийг цэвэрхэн байлгаж ариутгах халдваргүйжүүлэлт тогтмол хийсэн байна.	2.3. Говь-Алтай аймгийн Бургастай дахь гаалийн хороонд 1 эрэлч нохой. 2.4. Хөвсгөл аймаг дахь гаалийн хороонд 1 эрэлч нохой. 3. 2025 оны эхний хагас жилд давхардсан тоогоор 120 эрэлч нохдыг эмчилгээнд хамруулсан. 2025 оны 1,2,3 сард 15 нохой эмчилгээнд хамруулсан. ГЕГ-ын даргын 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн Б/137 тоот дугаар тушаалаар С.Мөнх-Эрдэнэ ЭНСТ-ийн малын эмчээр шинээр томилогдон ажиллаж 3,4,5 сард давхардсан тоогоор 105 эрэлч нохдыг тогтмол эрүүл мэндийн үзлэгт хамруулж шаардлагатай эм тариа туулгыг заасан хэмжээний дагуу зарцуулсан байна. Харьяа гаалийн газар хороодын хяналт шалгалтад ашиглаж байгаа эрэлч нохдын арчилгаа болон хооллолт нохойд өдөр тутмын илчлэгийн хэмжээг тодорхойлж нохойн хоолны хэмжээг тодорхойлох тухай болон эрүүл мэндийн зөвлөгөө мэдээллийг тогтмол хугацаанд өгч ажиллаж байна. 4. Гаалийн ерөнхий газрын дэргэдэх эрэлч нохойн сургалтын төвийн даргын баталсан жижүүрийн хуваарийн дагуу ГУАБ, ГУБ нар ээлжээр жижүүрлэн ажиллаж байна. Жижүүрүүд тухайн өдөр эрэлч нохдыг байрлуулах үүрний ариун цэвэр, барилга байгууламжуудын бүрэн бүтэн байдал, албан хаагч нарын өдөр тутмын ажилд хяналт тавьж тэмдэглэл хөтлөн ажиллаж байна. 2025 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр СОСУ ХХК Эрэлч нохойн сургалтын төвийн захиргаа, дотуур байр, сургалтын заал, мал эмнэлэг, арчилгааны байр болон сургалтын талбай орчинг мэрэгч шавьж устгалын ариутгал халдваргүйжүүлэлт хийсэн. Эрэлч нохдын үүрийг өдөр тутам тогтмол цэвэрлэж, 7 хоног бүрийн баасан гаригт тогтмол халдваргүйжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Мөн ЭНСТ нь албаны нохдын нохойн хоол болон ус уух идүүрийг шинэчилж солих саналыг судалгааны хамт 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 01501/55 тоот дотоод зурвасаар ГЕГ-ын ААҮА-руу хүргүүлсэн. Үүнтэй холбоотой албаны нохдод нохойн хоол болон ус уух идүүрийг худалдан авах ажлыг зохион байгуулахаар ажиллаж байна.		
2.	Албаны эрэлч нохойн	Хэрэгжилт, гүйцэтгэл эр.	2024 онд 1 удаагийн үржлийн	Эхний хагас жилд: - 2025 онд гаалийн байгууллагын нөөцөд	1. Гаалийн байгууллагын данс бүртгэлд бүртгэлтэй нохдыг үржлийн хөтөлбөрт хамруулах замаар нохой худалдан авах зардлыг хэмнэж эрэлч нохойн тоо толгойг нэмүүлэх	01.01-06.30	100

	үржүүлгийн талаар хийгдсэн ажил.	хөтөлбөр хэрэгжүүлж 4 гөлөг бойжуулсан.	байгаа эрэлч нохдын судалгаа гаргана. - Үржлийн хөтөлбөрийг боловсруулж ЭНСТ-ийн даргаар батлуулна. - Үржлийн хөтөлбөрт хамрагдах эрэлч нохдыг сонгож, үржлийн хөтөлбөрт хамруулна. Сүүлийн хагас жилд: - Үржлийн хөтөлбөрийн хүрээнд бойжуулан авсан гөлгөн нохдыг бойжуулна.	зорилгын хүрээнд үржлийн хөтөлбөрийг боловсруулж ЭНСТ-ийн даргаар батлуулсан. Тус хөтөлбөрийн хүрээнд 2025 оны үржлийг зохион байгуулахаар гаалийн ерөнхий газрын данс бүртгэлд байгаа 51 нохойнд үүлдэр, нас, бие физиологийн байдлаар судалгааг гаргахад үржилд орох боломжтой 4-6 насны эм нохойн тоо 12 ширхэг байгаагаас 3 нохой нь үржлийн хөтөлбөрт сонгогдож болохоор байсан. Бусад нохдын хувьд хол боомтуудад ажиллаж байгаа болон үүлдрийн хувьд таарахгүй байсан. Данс бүртгэлд бүртгэлтэй нохдыг үржлийн хөтөлбөрт хамруулах замаар нохой худалдан авах зардлыг хэмнэж эрэлч нохойн тоо толгойг нэмүүлэх зорилгын хүрээнд үржлийн хөтөлбөрийг боловсруулж ЭНСТ-ийн даргаар батлуулсан. Үржлийн хөтөлбөрийн хүрээнд үржилд хамрагдах боломжтой нохдоос УХШИГГ-ын Лоло дуудлагат 5 настай эм нохойг сонгосон.Тус нохой нь үүлдэрийн хувьд цөөн байдаг бие физиологийн хувьд хурдан шаламгай, үнэрлэх чадвар сайн гаалийн байгууллагад 2020 оноос албаны эрэлч нохойгоор ажиллаж байгаа. Үржлийн хувьд өмнө нийллэгт орж үзээгүй. Эр нохойн хувьд ЭНСТ-ийн Коко дуудлагат Швейцарь овчарка үүлдрийн нохойг сонгосон. Эм нохойн ороо 2-р сарын 25 нд орж нийллэгт орох графикийн дагуу 3-р сарын 11, 12 хоёр өдөр нийллэгт оруулсан. Нийллэгт орсон нохойн эрүүл мэндийн хяналтын дэвтэрийг нээж малын эмчийн хяналтад авсан. Өдөр бүрийн хяналтыг тавьж үзлэг хийн ажилласан. Нохой нийллэгт орсоноос хойш 9 дахь хоногоос бага зэргийн шингэн гарч эхлэн зохих эмчилгээг эхлүүлсэн боловч хээл авч чадаагүй. 2.ЭНСТ-ийн Молли дуудлагат малинуа үүлдрийн 4 настай охин нохойг үржилд оруулахаар сонгосон. Тус нохой нь өнгө зүс сайтай, хурдан шаламгай, үнэрлэх мэдрэхүй сайн хөгжсөн үүлдрийн хувьд албанд ашиглахад тохиромжтой. Эр нохойн УБГГ-ын Рома дуудлагат малинуа үүлдрийн нохойг сонгосон. Тус нохдыг 2-р сарын 6-нд нийлүүлсэн. Малинуа үүлдрийн Молли дуудлагат нохой 04-р сарын 04-ны өдөр төрсөн. Нийт 4 гөлөг гарсан. Үржлийн хөтөлбөрийн хүрээнд гарсан гөлөгний бойжуулах ажлын төлөвлөгөөг боловсруулж ЭНСТ-ийн даргаар батлуулж тус хөтөлбөрийн дагуу бойжуулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Тус ажлын хүрээнд мал эмнэлгийн тусгай зөвшөөрөл авах ажлыг эхлүүлэн шаардлагтай баримт бичгүүдийг		
--	---	--	---	---	--	--

					бүрдүүлэн холбогдох газруудад хүргүүлэн ажиллаж байна.		
3.	Албаны чадамж бүхий эрэлч нохойн сургалт.	Хэрэгжилт, гүйцэтгэлээр.	2024 онд 5 удаагийн сургалт төлөвлөснөөс гүйцэтгэлээр нийт 7 удаагийн сургалтыг зохион байгуулсан.	Эхний хагас жилд: - Эрэлч нохойн 3 удаагийн сургалт зохион байгуулж, гаалийн байгууллагад эрэлч нохойн чиглэлээр ажиллаж байгаа албан хаагчдад мэдээ мэдээлэл өгсөн байна. Сүүлийн хагас жилд: - Эрэлч нохойн 3 удаагийн сургалт зохион байгуулж, гаалийн байгууллагад эрэлч нохойн чиглэлээр ажиллаж байгаа албан хаагчдад мэдээ мэдээлэл өгсөн байна.	2025 оны эхний хагас жилийн тайлант хугацаанд нийт 4 удаагийн албаны чадамж бүхий эрэлч нохойн сургалт зохион байгуулан ажилласан нь 2025 онд нийт зохион байгуулахаар төлөвлөсөн эрэлч нохойн сургалтын 66.6 хувийг эхний 6-р сард зохион байгуулж, гаалийн газар хороодод эрэлч нохойн чиглэлээр ажиллаж байгаа албан хаагчдын 46 хувийг, эрэлч нохойн сургалтын төвийн төрийн тусгай албан хаагч нарын 66.6 хувийг эрэлч нохойн хамт сургалтад хамруулан ажилласан байна. Үүнд: 1. Гаалийн ерөнхий газрын дэд даргын баталсан “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын бодит үнэрт албаны эрэлч нохойг давтан сургах сургалтын хөтөлбөр”-ийн дагуу 2025 оны 01 дүгээр сарын 21-ний өдрөөс 2025 оны 01 дүгээр сарын 30 ний өдрийг дуустал хуанлийн 10 хоног буюу 80 цагийн сургалтад гаалийн 3 газар хороодын 12 албан хаагчийг эрэлч нохойн хамт хамруулсан. Сургалтад: 1.1. Улаанбаатар хот дахь гаалийн газрын эрэлч нохой хариуцсан гаалийн улсын байцаагч Б.Баясгалан, Ц.Мөнхтуул, Н.Давааням нар. 1.2. Чингис Хаан Олон Улсын нисэх буудал дахь гаалийн газрын эрэлч нохой хариуцсан гаалийн улсын ахлах байцаагч Н.Батсүх, эрэлч нохой хариуцсан гаалийн улсын байцаагч Г.Хатанбаатар, Б.Сарантуяа, П.Ууганбаяр, Ө.Өнөрчимэг, эрэлч нохой хариуцагч Б.Өсөхбаяр, Ц.Дашболд нар. 1.3. Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын эрэлч нохой хариуцсан гаалийн улсын байцаагч А.Отгонбаяр, С.Сугаржаргал нар хамрагдсан. Сургалтаар гаалийн байгууллага болон тагнуулын байгууллагын хамтын ажиллагааны хүрээнд тус байгууллагын хяналтан дор бодит мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг үнэрийг ашиглаж эрэлч ноходод үнэрийг таниулж ур чадварыг дээшлүүлсэн. 2. Гаалийн ерөнхий газрын дэргэдэх эрэлч нохойн сургалтын төвийн даргын баталсан “Албаны эрэлч нохойг сургах анхан шатны сургалтын хөтөлбөр”-ийн дагуу 2025 оны 02 дугаар сарын 03 ний өдрөөс 2025 оны	01.01-06.30	100

				04 дүгээр сарын 07 ний өдрийг дуустал ажлын 45 хоног буюу 360 цагийн сургалтад гаалийн 3 газар хороодын 4 албан хаагчийг эрэлч нохойн хамт хамруулсан. Сургалтад: 2.1. Улаанбаатар хот дахь гаалийн газрын эрэлч нохой хариуцсан гаалийн улсын байцаагч Г.Халиун, О.Мөнхцэцэг нар. 2.2. Баян-Өлгий аймаг дахь гаалийн газрын эрэлч нохой хариуцсан гаалийн улсын байцаагч З.Лашын. 2.3. Говь-Алтай аймгийн бургастай дахь гаалийн хорооны эрэлч нохой хариуцсан гаалийн улсын байцаагч Д.Даашинхүү нар хамрагдсан. Сургалтаар албан хаагч нарт албаны нохой сургах анхан шатны мэдэгдэхүүн, нохойн сургалтын онолын үндэс, арчилгаа маллагаа болон ашиглахтай холбоотой мэдлэг олгохоос гадна эрэлч нохдын хар тамхи мансууруулах бодис олж илрүүлэх чадварыг нэмэгдүүлсэн. 3. Гаалийн ерөнхий газрын дэргэдэх эрэлч нохойн сургалтын төвийн даргын баталсан “Албаны эрэлч нохойг сургах анхан шатны сургалтын хөтөлбөр”-ийн дагуу 2025 оны 04-р сарын 07 ний өдрөөс 2025 оны 04-р сарын 25 ний өдрийг дуустал ажлын 15 хоног буюу 120 цагийн сургалтад гаалийн 1 газар хорооны 1 албан хаагчийг эрэлч нохойн хамт хамруулсан. Сургалтад: 3.1. Хөвсгөл аймаг дахь гаалийн хорооны эрэлч нохой хариуцсан гаалийн улсын байцаагч Д.Сүнжидмаа хамрагдсан. 4. Гаалийн ерөнхий газрын дэргэдэх эрэлч нохойн сургалтын төвийн даргын баталсан “Гөлгөн нохойг албанд бэлтгэх анхан шатны сургалтын хөтөлбөр”-ийн дагуу 2025 оны 02-р сарын 10 ний өдрөөс 2025 оны 06-р сарын 30 ний өдрийг дуустал ажлын 100 хоног буюу 300 цагийн сургалтад эрэлч нохойн сургалтын төвийн ТТ-4 ТҮ-1 нийт 5 албан хаагчийг гөлгөн нохдын хамт хамруулсан. Сургалтад: 4.1. Эрэлч нохойн сургалтын төвийн дарга Б.Наранбадрах, гаалийн улсын ахлах байцаагч Я.Мөнхнасан, гаалийн улсын байцаагч Н.Ганболд, Б.Сарнай, гөлөг бойжуулагч Б.Улсболд нар хамрагдсан.	
--	--	--	--	---	--

4.	Эрэлч нохой ашиглалтыг нэмэгдүүлэх, зөрчил илрүүлэх чадварыг дээшлүүлэх талаар хэрэгжүүлсэн арга хэмжээ	Хэрэгжилт, гүйцэтгэл эр.	1.2024 онд 13 газар хороодод 33 эрэлч нохой ажилласан. 2.Зорчигчийн гар тээш, дагалдах ачаа, бараа, тээврийн хэрэгсэлд хийсэн шалгалтын тоонд эрэлч нохойг ашиглаж хийсэн шалгалтын хувийн жинг өмнө нь тооцож байгаагүй. 3.2024 онд бараа, тээврийн хэрэгслийг шалгах шатанд барааг гаалийн хилээр бусаар нэвтрүүлсэн, эсхүл нэвтрүүлэхийг завдсан зөрчлийн тоо 684. Үүнээс эрэлч нохой ашиглан илрүүлсэн зөрчлийн тоо 36 байсан.	Эхний хагас жилд: - Гаалийн газар хороодод ажиллаж байгаа эрэлч нохдын ашиглалт дээр хяналт тавьж ажилласан байна - Бараа, тээврийн хэрэгслийг шалгах шатанд эрэлч нохой ашиглаж, илрүүлсэн зөрчлийн тоог нэмэгдүүлсэн байна. - Гаалийн газар хороодоос эрэлч нохой ашиглалтын мэдээг хүлээн авч нэгтгэж, тайлагнасан байна. - Гаалийн газар хороодын эрэлч нохойн ашиглалтын 6 сарын мэдээг цуглуулж үнэлгээ өгсөн байна. Сүүлийн хагас жилд: - Гаалийн газар хороодод ажиллаж байгаа эрэлч нохдын ашиглалт дээр хяналт тавьж ажилласан байна. - Бараа, тээврийн хэрэгслийг шалгах шатанд эрэлч нохой ашиглаж, илрүүлсэн зөрчлийн тоог нэмэгдүүлсэн байна. - Гаалийн газар хороодоос эрэлч	Гаалийн Ерөнхий газрын харьяа 13-н газар хороодод 33 эрэлч нохойг хяналт шалгалтад ашиглаж байна. Сар бүр эрэлч нохойн ашиглалтын мэдээг CERP программд газар хороод байршуулж мөн өдөр тутмын нохой ашиглалтын мэдээг хилийн хөдөлгөөний мэдээ цэсэнд байршуулан ЭНСТ-өөс хяналт тавин ажиллаж байна. Гаалийн хяналтад эрэлч нохойг ашигласан үзүүлэлтийн хувийг /E/ гаргахад зорчигчийн гар тээш, дагалдах ачаа бараа, тээврийн хэрэгсэлд хийсэн шалгалтын нийт тоонд эрэлч нохойг ашиглан хяналт шалгалтын хувийн жин /E1/ дээр Гаалийн хяналт шалгалтаар илрүүлсэн зөрчлийн тоонд эрэлч нохойн ашиглаж илрүүлсэн зөрчлийн тоог /E2/ нэмээд 2-т хуваахад гарна. $E=(E1+E2)/2$ 1-р сард E1- 0,28% E2- 0 E=0,14% 2-р сард E1- 1,47% E2- 1,81% E= 1,64% 3-р сард E1- 0,77% E2- 0,39% E= 0,58% 4-р сард E1- 1.05% E2-1.23% E= 1.14% 5-р сард E1-1.27% E2-0,63% E= 0,95% 2025 он гарсанаар эрэлч нохойг ашиглан нийт 14 зөрчил илрүүлсэн байгаагаас эрүүгийн 3 зөрчил байна. - ЗҮГГ-1 зөрчил - СЭГГ- 7 зөрчил - УХШИГГ- 4 зөрчил - ШХГГ-1 зөрчил - ДоГГ-1 зөрчил илрүүлсэн байна. Эрэлч нохойг гаалийн хяналт шалгалтад ашигласан байдал: 1-р сард Тээврийн хэрэгсэл- 3,507.80 Зорчигчийн гар тээш, дагалдах ачаа бараа- 9,596.15 2-р сард Тээврийн хэрэгсэл- 8,522 Зорчигчийн гар тээш, дагалдах ачаа бараа- 63,224.65	01.01-06.30	100

				нохой ашиглалтын мэдээг хүлээн авч нэгтгэж, тайлагнасан. - Албаны эрэлч нохойн ашиглалтын мэдээг нэгтгэж, CAIS программд мэдээллийн санг үүсгэсэн. - Гаалийн газар хороодын эрэлч нохойн ашиглалтын 6 сарын мэдээг цуглуулж үнэлгээ өгсөн байна.	3-р сард Тээврийн хэрэгсэл- 10,614 Зорчигчийн гар тээш, дагалдах ачаа бараа- 49,789 4-р сард Тээврийн хэрэгсэл- 6,372 Зорчигчийн гар тээш, дагалдах ачаа бараа- 71,760.7 5-р сард Тээврийн хэрэгсэл- 8,290 Зорчигчийн гар тээш, дагалдах ачаа бараа- 73,871 Эрэлч нохой ашиглалтыг нэмэгдүүлэх хүрээнд газар хороодод ажиллаж байгаа нийт ЭНХГУАБ, ЭНХГУБ нарт цахимаар 2 удаагийн хурлыг зохион байгуулан зөвлөмж хүргэн ажилласан.		
5.	Бусад байгууллага тай хамтран ажилласан байдал.	Хэрэгжилт, гүйцэтгэл эр.	2024 онд 1 удаа бусад байгууллагуудтай хамтран ажиллахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр нийт 7 удаа бусад байгууллагуудтай хамтран ажилласан.	Эхний хагас жилд: - Гадаад, дотоодын нохой сургалтын төвүүдтэй 1 удаа хамтран ажиллаж, харилцсан байна. Сүүлийн хагас жилд: - Гадаад, дотоодын нохой сургалтын төвүүдтэй 1 удаа хамтран ажиллаж, харилцсан байна.	2025 оны эхний хагас жилийн тайлант хугацаанд гадаадын эрэлч нохойн сургалтын төвтэй 1 удаа, Монгол Улсын цагдаагийн байгууллагатай 4 удаа нийт 5 удаа бусад байгууллагатай хамтран ажилласан. Үүнд: 2025 оны 02 дугаар сарын 12 ний өдөр Бүгд Найрамдах Солонгос Улсын гаалийн байгууллагын эрэлч нохойн сургалтын төвтэй цахимаар уулзах уулзалтыг зохион байгуулсан. Уулзалтад: - Эрэлч нохойн сургалтын төвийн дарга Б.Наранбадрах - Эрэлч нохойн сургалтын төвийн ГУАБ Я.Мөнхнасан - Эрэлч нохойн сургалтын төвийн ГУБ Н.Ганболд - Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн ГУБ Э.Энхтуяа - Мэдээллийн технологийн газрын ГУАБ Н.Мөнхзул нар оролцсон. Уулзалтаар Монголын гаалийн байгууллагын үржлийн хөтөлбөрийн хүрээнд бойжуулан авсан гөлгөн нохдыг Бүгд Найрамдах Солонгос Улсын гаалийн байгууллага сонирхож байгаа талаар дурьдсан. Уг гөлгөн нохдын зураг болон гаалийн ерөнхий газрын дэргэдэх эрэлч нохойн сургалтын төвийн даргын баталсан “Гөлгөн нохойг албанд бэлтгэх анхан шатны сургалтын хөтөлбөр”-ийг гаалийн ерөнхий газрын гадаад хамтын ажиллагааны хэлтсээр дамжуулан Бүгд	01.01-06.30	100

				найрамдах Солонгос улсын гаалийн байгууллагын эрэлч нохойн сургалтын төвд хүргүүлсэн. Бүгд Найрамдах Солонгос Улсын гаалийн байгууллагаас тус гөлгөн нохдыг тодорхой саруудад хүрэх болгонд цахимаар холбогдож санал хүсэлтээ солилцохоор болсон. 2. 2025 оны 03 дугаар сарын 14 ний өдөр Онцгой байдлын ерөнхий газар болон Цагдаагийн ерөнхий газрын албаны нохойн асуудал эрхэлсэн албаны удирдлага, сургагч багш нартай уулзах уулзалтыг зохион байгуулсан. Уулзалтаар байгууллага тус бүрийн сургалтын онцлог хийж хэрэгжүүлж байгаа болон цаашид хийхээр төлөвлөсөн ажил, ашиглаж байгаа эрэлч нохдын төрөл, сургалтын тоног хэрэгсэл, хэрэглэгдэхүүн болон бусад техник тоног хэрэгсэлтэй танилцсан. 3. Төв аймгийн цагдаагийн газраас 2025 оны 04-р сарын 29 ний өдөр Гаалийн ерөнхий газрын дэд даргад 47/01-2606 тоот албан бичгээр гаалийн байгууллагын эрэлч нохойн сургалтын төвтэй хамтран ажиллах “Санамж бичиг” байгуулах саналыг ирүүлсэн. Уг саналын дагуу гаалийн байгууллагын удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу хамтран ажиллах санамж бичгийн төслийг боловсруулан. 2025 оны 05-р сарын 01 ний өдөр цагдаагийн байгууллагыг төлөөлж Төв аймгийн цагдаагийн газрын дарга хурандаа Б.Баянмөнх, гаалийн байгууллагыг төлөөлж эрэлч нохойн сургалтын төвийн дарга Б.Наранбадрах нар гарын үсэг зурж баталсан. 4. Цагдаагийн ерөнхий газрын тээврийн цагдаагийн албаны иргэний агаарын тээврийн цагдаагийн хэлтсээс 2025 оны 05-р сарын 16 ний өдөр Гаалийн ерөнхий газрын дэд даргад 14-36/341 тоот албан бичгээр Цагдаагийн байгууллагаас “Өнөөдөр сонго, маргааш бүтээцгээе” уриан дор зохион байгуулах нээлттэ хаалганы өдөрлөгт гаалийн байгууллагын эрэлч нохойн сургалтын төвийг оролцуулах хүсэлтэй байгаа тухай мэдэгдсэн. Гаалийн ерөнхий газрын дэд даргаас цагдаагийн байгууллагын ирүүлсэн хүсэлтийг үндэслэн хамтран чиглэл өгсөний дагуу 2025 оны 05-р сарын 23		
--	--	--	--	--	--	--

					ний өдөр Улаанбаатар хот Сүхбаатарын талбайд зохион байгуулагдсан “Өнөөдөр сонго, маргааш бүтээцгээе” уриатай нээлттэй хаалганы өдөрлөгт гаалийн байгууллагын 7 албан хаагч 4 эрэлч нохойн хамт оролцож гаалийн байгууллагын эрэлч нохой ашиглалт болон сургалтын үйл ажиллагааны болон бусад холбогдох мэдээ мэдээлэлийг танилцуулах, албаны нохдын ур чадварыг иргэд олон нийтэд тайлбарлан танилцуулсан. 5. Цагдаагийн ерөнхий газрын тээврийн цагдаагийн албаны иргэний агаарын тээврийн цагдаагийн хэлтсээс 2025 оны 06-р сарын 02 ний өдөр Гаалийн ерөнхий газрын дэд даргад 14-3/411 тоот албан бичгээр Цагдаагийн ерөнхий газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 08 ний өдөр баталсан “Эргүүл ажиллуулах тухай” тушаалын хэрэгжилтийг хангах чиглэлээр Чингис Хаан Олон Улсын нисэх буудал орчим цагдаагийн байгууллагын албан хаагч нар 2025 оны 06-р сарын 01 ний өдрөөс 2025 оны 10 дугаар сарын 01 ний өдрийг дуустал хугацаанд эргүүл ажиллуулах гэж байгаа тухай мэдэгдэж Цагдаагийн байгууллагын эргүүлийн бүрэлдэхүүнд албаны нохой багтсан тул дээрх нохдыг тус арга хэмжээ дуустал гаалийн байгууллагын эрэлч нохойн сургалтын төвд байршуулах хүсэлтийг ирүүлсэн. Гаалийн ерөнхий газрын дэд даргаас зохион байгуулалтын арга хэмжээ авч хамтран ажиллах тухай чиглэл өгсөний дагуу 2025 оны 06-р сарын 03 ний өдрөөс эхлэн цагдаагийн байгууллагын албаны нохдыг гаалийн байгууллагын эрэлч нохойн сургалтын төвийн малын эмчийн үзлэгт хамруулан, урьдчилан ариутгаж бэлтгэсэн үүрэнд байрлуулж орох гарах хөдөлгөөнд нь хяналт тавин ажиллаж байна.		
6.	Бодлогын баримт бичгийн зорилт, арга	Хэрэгжилт, гүйцэтгэл эр	Нэгжийн үйл ажиллагаанд хамааралтай бодлогын баримт бичгүүд	Эхний хагас жилд: Эрэлч нохойн сургалтын төвийн чиг үүрэгтэй холбоотой бодлогын баримт	1. Эрэлч нохойн сургалтын төвийн чиг үүрэгтэй холбоотой бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээнд 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/714 тоот "Гаалийн байгууллагын хүний нөөцийн бодлогын баримт бичиг"	01.01-06.30	100

	хэмжээний хэрэгжилт.		байгаагүй болно.	бичигт тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажиллаж тайлагнасан байна. Сүүлийн хагас жилд: Эрэлч нохойн сургалтын төвийн чиг үүрэгтэй холбоотой бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажиллаж тайлагнасан байна.	батлагдсныг эрэлч нохойн сургалтын төвийн нийт албан хаагчдад танилцуулан арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2. Эрэлч нохойн сургалтын төвийн чиг үүрэгтэй холбоотой бодлогын баримт бичгийн хүрээнд дараах урт хугацааны бодлогын баримт бичгийг судлан ажилласан. Үүнд: 2.1."Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого; 2.2.Хөгжлийн зорилтот хөтөлбөр; 2.3.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр; 2.4.Үндэсний хөтөлбөр дэд хөтөлбөр; 2.5.Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө.		
7.	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт.	Хэрэгжилт ийн эерэг үзүүлэлт	2024 онд нэгжийн үйл ажиллагаатай холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилтийг ханган ажилласан.	Эхний хагас жилд: - Эрэлч нохойн сургалтын төвийн үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж эрх зүйн актын судалгаа хийж жагсаалт гаргасан байна. - Эрэлч нохойн сургалтын төвийн үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж эрх зүйн актуудын талаарх танилцуулгыг албан хаагч нарт танилцуулсан байна. - Эрэлч нохойн сургалтын төвийн үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжуудын хэрэгжилтийг ханган ажиллаж тайлагнасан байна.	1.Эрэлч нохойн сургалтын төвийн үйл ажиллагаа, чиг үүрэгтэй холбогдох хууль тогтоомж, гаалийн ерөнхий газрын даргын баталсан дотооддоо дагаж мөрдөх эрх зүйн актуудыг албан хаагч нарт тайлбарлан таниулах ажлыг зохион байгуулж Гаалийн ерөнхий даргын 2019 оны А/271 дугаар тушаалын хавсралт "ГААЛИЙН БАЙГУУЛЛАГЫН БЭЛГЭ ТЭМДГИЙН ТУХАЙ ЖУРАМ"-ыг танилцуулсан. 2.Төрийн үйлчилгээний албан хаагчдын хөдөлмөрийн гэрээг хуулийн хэлтсээр хянуулж, хүний нөөцөд бүртгүүлсэн. 3. Эрэлч нохойн сургалтын төвийн чиг үүрэгтэй холбоотой хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих бодлогын баримт бичиг, хууль тогтоомжийн судалгааг хийж хэрэгжилтийг тайлагнасан. Үүнд: 3.1. 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/714 тоот "Гаалийн байгууллагын хүний нөөцийн бодлогын баримт бичиг" 3.2. Гаалийн ерөнхий газрын даргын 2017 оны А/181 дугаар тушаалын хавсралт "ГААЛИЙН АЛБАНЫ ЭРЭЛЧ НОХОЙН СОНГОЛТ, НӨХӨН ХАНГАЛТ, БҮРТГЭЛЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ"; 3.3. Гаалийн ерөнхий газрын даргын 2008 оны 573 дугаар тушаалын хавсралт "ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧИЙН ТУСГАЙ ХЭРЭГСЭЛ, ТҮҮНИЙГ ХЭРЭГЛЭХ, ХАДГАЛАХ ЗААВАР";	01.01-06.30	100

				Сүүлийн хагас жилд: - Эрэлч нохойн сургалтын төвийн үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж эрх зүйн актуудын талаарх танилцуулгыг албан хаагч нарт танилцуулсан байна. - Эрэлч нохойн сургалтын төвийн үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжуудын хэрэгжилтийг ханган ажиллаж тайлагнасан байна.	3.4. Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн А/176 дугаар тушаалын хавсралт “ЭРЭЛЧ НОХОЙ СУРГАЛТЫН ТӨВИЙН ДҮРЭМ”; 3.5.“Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, Зорилт 1.3 Монгол хэл, бичгээ үндэсний үнэт зүйлийн бүрдэл болгон иргэн бүр чанартай эзэмшиж хэрэглэж хэвшинэ. 3.6.“Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа. Зорилт 2.1 хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлнэ.		
8.	Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал.	Хэрэгжилтийн эерэг үзүүлэлт	Эрэлч нохойн сургалтын үйл ажиллагаанд 2024 оноос нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх ажлыг эхлүүлсэн. Ажлын хүрээнд 5 эрсдэлийг таньж тогтоосон. ГЕГ-ын ХШҮДАГ, ЭУХ, ДХАБХ-ээс хамтран зохион байгуулсан “Эрсдэлийн удирдлагын хэрэгжүүлэх онол, практикийн асуудал”	Эхний хагас жилд: - Эрэлч нохойн сургалтын төвийн 2024 оны эрдэлд дүн шинжилгээ хийсэн байна. - Эрсдлийн судлагааг давтан зохион байгуулсан. - Тогтоогдсон эрсдэлд бууруулах арга хэмжээ авсан байна. Сүүлийн хагас жилд: - Эрэлч нохойн сургалтын төвийн ажлын байран дээр тохиолдох эрсдлийг давтан судалж, бууруулах арга хэмжээ авсан байна.	1.Эрэлч нохойн сургалтын төвийн 2024 оны эрсдэлд дүн шинжилгээ хийж, нэгжийн эрсдлийн санг баяжуулж, эрсдлийг бууруулах, шилжүүлэх арга хэмжээг авч ажилласан. Тогтоогдсон эрсдэлд бууруулах арга хэмжээ авсан. 1.1. Эрэлч нохойтой ажиллахдаа нохойд хазуулах эрсдэл, халдварт өвчнөөс урьпчилан сэргийлэх зорилгоор гаалийн байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нийтлэг зааварчилгааг өдөр бүр өгч гарын үсэг зуруулж баталгаажуулсан. 1.2. Эрэлч нохойн эрүүл мэндийг хамгаалах, өвчлөлөөс урьдчилан сэргийлж малын эмчийн үзлэгт хамруулах вакцин туулгад цаг тухай бүр хамрагдуулсан. 1.3. Нохойноос хүнд халдварладаг олон төрлийн өвчин байдаг тул эрүүл ахуйн зааварчилгааг мөрдөж ажиллах, хувийн ариун цэврийг чанд сахихыг зөвлөх мөн арчилгаа маллагааны байр, мал эмнэлэг, сургалтын заал, нохойны үүрэнд өдөр бүр цэвэрлэгээ үйлчилгээ хийгдэж байна. 1.4. Хувь хүний харилцаа хандлагын доголдол гаргахаас сэргийлж нийт албан хаагчдад төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон төрийн албаны тухай хуулийг танилцуулах хувиарлалтыг гарган ажиллаж байна.	01.01-06.30	100

			сургалтад 1 албан хаагч хамрагдсан.		1.5. Ажил таслалт, хоцролтыг хянах ажил цалгардахаас сэргийлж гаалийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг танилцуулж гарын үсэг зуруулж баталгаажуулсан. 2. Эрэлч нохойн сургалтын төвийн бүх албан хаагчдаас Google forms ашиглан нэгжийн эрсдлийг тодорхойлох зорилгоор асуумж судалгааг 2025-ны 1 дүгээр сарын 17-ны өдөр авсан. 4.Гадаад болон дотор орчны аюулт үзэгдэлд өртөж болохуйц эрсдэлтэй газруудыг тодорхойлох, мөн өдөр тутам гарч болзошгүй судалгааг хийсэн. Сургалтын байгууллагын гадар болон дотор орчныг үнэлэхдээ жижиг, том боломжит аюулт эрсдлүүдийг тооцож бууруулах арга хэмжээг авсан. 5.2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр эрэлч нохойн сургалтын төвийн нохойн үүр болон байрнуудад ариутгал халдваргүйжүүлэлтийг хийж нохойноос хүнд халдварладаг өчнин эмгэгээс албан хаагч өөрийгөө хэрхэн хамгаалах арга хэмжээний талаар зөвлөмж өгсөн. 6.Гаалийн ерөнхий газраас нийт албан хаагчдыг гэнэтийн ослоос урьдчилан сэргийлж “Хаан даатгал”-д амь даатгалд хамрагдуулсан.		
9.	Үүрэг даалгаврын биелэлт.	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	2024 онд захиргаа дотоод ажлын системээр өгөгдсөн 10 үүрэг даалгаврыг хугацаанд нь биелэлтийг хангаж тайлагнасан.	Эхний хагас жилд: - Өгөгдсөн үүрэг даалгавруудыг хугацаанд нь бүрэн биелүүлж ажилласан байна. Сүүлийн хагас жилд: - Өгөгдсөн үүрэг даалгавруудыг хугацаанд нь бүрэн биелүүлж ажилласан байна.	1. 2025 оны эхний хагас жилд захиргаа, дотоод ажлын системийн үүрэг даалгаварын цэсэнд нийт 15 үүрэг даалгавар өгөгдсөн байна. Үүнд: 1.1. 2025.01.27-2025.01.31-ны өдрийг хүртэлх 1 үүрэг даалгавар, 1.2. 2025.04.02-2025.04.18-ны өдрийг хүртэлх 1 үүрэг даалгавар, 1.3. 2025.01.07-2025.06.02-ны өдрийг хүртэлх 12 үүрэг даалгавар, 1.4. 2025.05.21-2025-06.05-ны өдрийг хүртэлх 1 үүрэг даалгавар өгөгдсөнөөс 2 үүрэг даалгаварын биелэлтийг хангаж хугацаанд нь оруулж 100%-р дүгнэгдэж, 13 үүрэг даалгаварын биелэлтийг хугацаанд нь ханган ХШҮДАГ руу илгээсэн төлөвтэй байна.	01.01-06.30	100
10.	Ажлын цаг ашиглалт.	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	2024 онд ТТ албан хаагч 6, ТҮ албан хаагч 9, нийт 15 албан хаагч ажилласан. Ажиллах хугацаанд ажил	Эхний хагас жилд: - Гаалийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 9.3.4-т заасны дагуу Гаалийн удирдах төв байгууллагын албан	1. 2025 оны эхний хагас жилд ЭНСТ-д нийт ТТ албан хаагч 6, ТҮ албан хаагч 10 ажиллаж байна. ЭНСТ-ийн албан хаагч нар өглөө ажилд ирэх болон тарах цагийг Хөшигийн хөндийн ЧХОУНБГГ-ын захиргааны байрны 3 давхарт байрладаг цаг бүртгэлийн цахим төхөөрөмжид бүртгүүлдэг. Бүртгэгдсэн цагийн мэдээллийг ГЕГ-ын ЗУГ-с тогтмол татаж аван хяналт тавьдаг. ЭНСТ-ийн ажилчид албан томилолт, гадуур	01.01-06.30	100

			тасалсан албан хаагч байхгүй.	хаагч гадуур ажиллах, албан томилолтоор ажиллах, ээлжийн амралтаа эдлэх, чөлөө авах зэрэг бусад хүсэлтэд хяналт тавьж ажилласан байна. - Албан хаагч нарын ажлын цаг ашиглалт дээр хяналт тавьж ажилласан байна. Сүүлийн хагас жилд: - Гаалийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 9.3.4-т заасны дагуу Гаалийн удирдах төв байгууллагын албан хаагч гадуур ажиллах, албан томилолтоор ажиллах, ээлжийн амралтаа эдлэх, чөлөө авах зэрэг бусад хүсэлтэд хяналт тавьж ажилласан байна. - Албан хаагч нарын ажлын цаг ашиглалт дээр хяналт тавьж ажилласан байна.	ажиллах, ээлжийн амралт, чөлөө зэргийг захиргаа дотоод ажлын системийн амралт, чөлөө томилолт цэсээр орж албан ёсны хүсэлт илгээн нэгжийн даргаар хянуулж ЗУГ-аар батлуулдаг. 2. ЭНСТ нь 2025 оны эхний хагас жилд 4 сул орон тоо нөхөгдсөн. Үүнд: 2.1. ГЕГ-ын даргын 2025 оны 01 дугаар сарын 09-ны өдрийн Б/20 дугаар тушаалаар Д.Цэрэнчимэд ЭНСТ-ийн няраваар, 2.2. ГЕГ-ын даргын 2025 оны 01 дугаар сарын 09-ны өдрийн Б/21 дугаар тушаалаар Б.Тэмүүлэн ЭНСТ-ийн үйлчлэгчээр, 2.3. ГЕГ-ын даргын 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн Б/120 дугаар тушаалаар Ц.Түвшинбат ЭНСТ-ийн маллагчаар, 2.4. ГЕГ-ын даргын 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн Б/137 тоот дугаар тушаалаар С.Мөнх-Эрдэнэ ЭНСТ-ийн малын эмчээр тус тус шинээр томилогдон ажиллаж байна. 2.5. ЭНСТ-ийн дарга Б.Наранбадрахаар батлуулсан хуваарийн дагуу хагас бүтэн сайны амралтын өдөр болон бүх нийтийн амралтын өдрүүдээр нохой хооллох хуваарийн дагуу албан хаагч нар хяналт тавьж ажиллаж байна.		
11.	Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт.	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	2024 онд эрэлч нохойн сургалтын төвийн үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг	Эхний хагас жилд: - Цаг үеийн шинжтэй үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн ажлуудын биелэлт уялдаа холбоог хангаж тухай	1. 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр Хөшгийн хөндийд байрлах Гаалийн ерөнхий газрын дэргэдэх Эрэлч нохойн сургалтын төвд мэдээлэл олгох Сургалтын төвийн ГУАБ Ч.Эрдэнэбат болон ЭНСТ ГУАБ Я.Мөнхнасан нар зохион байгуулсан. Уг сургалтад хамрагдсан албан тушаалтан:	01.01-06.30	100

			үүргийн 6 ажлын биелэлтийг хангаж ажилласан.	бүр тайлагнаж ажилласан байна. Сүүлийн хагас жилд: - Цаг үеийн шинжтэй үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн ажлуудын биелэлт уялдаа холбоог хангаж тухай бүр тайлагнаж ажилласан байна.	1. Гаалийн ерөнхий газрын харьяа ЧХОУНБГГ-ын 6 албан хаагч 2. Улаанбаатар хотын гаалийн газрын 3 албан хаагч 3. УХШИГГ-ын 2 албан хаагч 4. Эрэлч нохойн сургалтын төвийн 4 албан хаагч нийт 15 албан хаагч сургалтад хамрагдсан. 2. “Гаалийн байгууллагын удирдах ажилтны сургалт, зөвөлгөөн 2025” хөтөлбөрт Панел хэлэлцүүлэг №1: ЭНСТ-ийн дарга Б.Наранбадрах оролцсон. 3. “Гаалийн байгууллагын удирдах ажилтны сургалт, зөвөлгөөн-2025” хөтөлбөрт ГУАБ Я.Мөнхнасан үйл ажиллагааны зохион байгуулалтын хэсэгт ажилласан. 4. Гаалийн ерөнхий газрын даргын 2025.01.14-ний өдрийн № А/06 тоот “Үнэлгээний хороо байгуулах тухай” тушаалаар гаалийн байгууллагын эрэлч нохдод зориулалтын хоол нийлүүлэх тендерийн сонгон шалгаруулалтанд ЭНСТ-ийн ГУАБ Я.Мөнхнасан үнэлгээний хорооны гишүүнээр ажилласан. 5. 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдөр "Сэлбэ" олон улсын сургуулийн 3 дугаар ангид суралцдаг 17 хүүхдийг Гаалийн ерөнхий газрын дэргэдэх эрэлч нохойн сургалтын төвийн үйл ажиллагаа дотоод зохион байгуулалт захиргаа, нохойн арчилгаа маллагааны байр, мал эмнэлэг, сургалтын заал болон эрэлч нохойн хэрэгсэлтэй үзүүлбэр, нохойн зорилтот үнэр эрэх хайх сургалтын хэсгээс 1. Б.Наранбадрах ЭНСТ дарга 2. А.Энх-Амгалан ЭНСТ ГУБ 3. Т.Нандин-Эрдэнэ ЭНСТ ГУБ 4. Б.Сарнай ЭНСТ ГУБ нар үзүүлж танилцуулсан.		
--	--	--	---	---	--	--	--

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
1.	Үүрэг даалгаварын биелэлт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	2024 онд захиргаа дотоод ажлын системээр өгөгдсөн 10 үүрэг даалгаврыг хугацаанд нь биелэлтийг хангаж тайлагнасан.	1. 2025 оны эхний хагас жилд захиргаа, дотоод ажлын системийн үүрэг даалгаварын цэсэнд нийт 15 үүрэг даалгавар өгөгдсөн байна. Үүнд: 1.1. 2025.01.27-2025.01.31-ны өдрийг хүртэлх 1 үүрэг даалгавар, 1.2. 2025.04.02-2025.04.18-ны өдрийг хүртэлх 1 үүрэг даалгавар, 1.3. 2025.01.07-2025.06.02-ны өдрийг хүртэлх 12 үүрэг даалгавар, 1.4. 2025.05.21-2025- 06.05-ны өдрийг хүртэлх 1 үүрэг даалгавар өгөгдсөнөөс 2 үүрэг даалгаварын биелэлтийг хангаж хугацаанд нь оруулж 100%-р дүгнэгдэж, 13 үүрэг даалгаварын биелэлтийг хугацаанд нь ханган ХШҮДАГ руу илгээсэн төлөвтэй байна.	2025.01.01 - 2025.06.30	100%

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
			1	2	3	4	5

1.	Төрийн албаны сургалтанд хамрагдах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	-	Гаалийн байгууллагаас зохиосон сургалтад хамрагдсан.	2025.01.01 - 2025.06.30	90%
2.	Шинээр гарсан хууль тогтоомж, журмыг бие даан судалж, хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	Төрийн удирдлага чиглэлээр их дээд сургуульд хамрагдсан байна.	-	Шинээр гарсан хууль тогтоомж, бодлогын баримт бичиг хууль тогтоомжийг судалж эрх зүйн мэдлэгээ дээшлүүлсэн.	2025.01.01 - 2025.06.30	90%

ТАЙЛАН ГАРГАСАН:

Эрэлч нохойн сургалтын төвийн
гаалийн улсын байцаагч
(Албан тушаал)

А.Энх-Амгалан / *А. Энх-Амгалан*
(Нэр, гарын үсэг)

2025 / 6 / 9
(Огноо)

АНХБАЯРЫН ЭНХ-АМГАЛАНГИЙН 2025 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН,
МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС
(ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ)

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар

Нэгжийн нэр: Эрэлч нохойн сургалтын төв

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4	5
	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	
Зорилт 1. Зорилт 1. "Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх" зорилтыг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт					
1.	Албаны эрэлч нохойн амьдрах, сургах орчин нөхцөлийг сайжруулсан байдал	60	10	70	
2.	Албаны эрэлч нохойн үржүүлгийн талаар хийгдсэн ажил	60	10	70	
3.	Албаны чадамж бүхий эрэлч нохойн сургалт	60	10	70	
4.	Эрэлч нохой ашиглалтыг нэмэгдүүлэх, зөрчил илрүүлэх чадварыг дээшлүүлэх талаар хэрэгжүүлсэн арга хэмжээ	60	10	70	
5.	Бусад байгууллагатай хамтран ажилласан байдал	60	10	70	
6.	Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт	60	10	70	
7.	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт	60	10	70	
8.	Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал	60	10	70	
9.	Үүрэг даалгаварын биелэлт	60	10	70	
10.	Ажлын цаг ашиглалт	60	10	70	
11.	Үндсэн шалгуурт тусгагдагүй бусад чиг үүргийн хэрэгжилт	60	10	70	
Нэмэлт үүрэг даалгаврын биелэлт					
1.	"Байгууллагын үйл ажиллагаанд эрсдэл тооцон эрсдэлийг бууруулах" чиглэлээр чадавхжуулах;	60	10	70	
2.	Чиг үүрэгтэй холбоотой хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих бодлогын баримт бичиг, хууль тогтоомжийн жагсаалтыг гаргаж, тодорхой тайлагнах;	60	10	70	

Дундаж оноо:

70.0

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Нийт (15 хүртэл оноогоор)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4
1.	Төрийн албаны сургалтанд хамрагдах	50%	13	
2.	Шинээр гарсан хууль тогтоомж, журмыг бие даан судалж, хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх	50%	14	
Дундаж оноо			13,5	

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3
1.	Хандлага, ёс зүй	7	
2.	Дүн шинжилгээ хийх	7	
3.	Асуудал шийдвэрлэх	6	
4.	Хариуцлагатай байдал	6	
5.	Ажлын цаг ашиглалт	7	
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)			
6.	Албаны нохой сургалт	7	
7.	Чиг үүрэгтэй холбоотой хууль тогтоомж судлах	7	
Дундаж оноо		6,7	

4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Хамт олны үнэлгээ (0-8 оноо)
	1	2
1.	Хандлага, ёс зүй	7
2.	Багаар ажиллах	7
3.	Харилцаа	7
Дундаж оноо		7

5. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)	70
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	13,5
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)	6,7
4.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)	7

5.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	(97,2 оноо)
Нийт оноо = (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо (Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо		97.2

Үнэлгээ өгсөн:

Нэгжийн дарга

Эрэлч нохойн сургалтын төвийн дарга



(Б.Наранбадрах)


2025/06/10 (огноо)

Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:

Төрийн жинхэнэ албан хаагч:

зөвшөөрсөн:

Гаалийн улсын байцаагч




(А.Энх-Амгалан)

2025/06/10 (огноо)

Үнэлгээг хянасан:

Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:

Дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч




(Г.Энхтайван)

2025.06.25 (огноо)

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:

Хүний нөөцийн хэлтсийн гаалийн улсын ахлах байцаагч



(Ө.Тэгшээ)

2025.06.25 (огноо)

Үнэлгээг баталгаажуулсан:

Төсвийн шууд захирагч

Гаалийн ерөнхий газрын дарга



(Р.Отгонжаргал)

2025.06.25 (огноо)